

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04-р сарын 15-ны өдөр

Дугаар:26/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2026.04.15-ны өдрийн 15.00 цагт эхлэв.

“Хүрд“ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж танилцууллаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаярын танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 124,421.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 91.98 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д "Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно" гэж заасныг бүрэн хангаж байгааг танилцуулж, хурал хуралдуудах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хуралд Э.Тэмүүжин, Б.Сумьяа, Б.Бат-Эрдэнэ, Э.Мөнх-Оргил, Б.Мөнхбат, С.Мягмарсүрэн, С.Эрдэнэчимэг , С.Пүрэвжав, Б.Батсайхан нарын 9 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа ээлжит хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг Тооллогын комиссоос авч гишүүдэд мэдээлж, Хурлын удирдлага, хурлын нарийн бичгийг томилох /ХЗБ Комисс/
2. Хурлын ирц мэдээлэгдсэнээс хойш хурлын явцад хуралд ирэгсдийг бүртгэн авч, саналын хуудас олгохгүй.
3. Хурлаар хэлэлцэх асуудлын талаар хурал даргалагч /ТУЗ-ийн дарга/ Б. Мөнхбат танилцуулах
4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан /Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин/
5. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулна. /Хурлын дарга/
6. Хэлэлцэж буй асуудлын талаар санал, асуулт хэлэлцэх. Хүн бүр 5 минут.
7. Хэлэлцэж буй асуудлаар санал хэлэхдээ зохисгүй, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, өөрийн саналыг бусдаар дэмжүүлэхийг уриалахгүй байх.
8. Хурлын үеэр чанга ярих, утсаар ярих, бичлэг хийхгүй байх

9. Хурлын явцад хурлыг түр орхиж гарах, чөлөө авах бол хурал даргалагчаас зөвшөөрөл авах
10. Хурлаар баталсан дэгийг зөрчсөн тохиолдолд хурал даргалагч эхний удаа сануулах, дараагийн удаа хурлаас чөлөөлөх арга хэмжээ авах
11. Тооллогын комисс саналын хуудсыг хүлээн авах.
12. Санал хураалтын дүн бүрээр тогтоол гаргаж, хуралд танилцуулах.
13. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж, тогтоолоо батлах.
14. Хурлыг 15:00 цагт эхэлнэ. Хурал 1 цаг үргэлжлээд 10 минут завсарлана. Хурлыг 1 цаг 30 минутад багтаах.
15. Хуралд оролцогчдын 75-с дээш хувийн саналаар хурлын цагийг сунгах.
16. Хурлын дарга үг хэлж хурлыг хаах.

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
5. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

1-р асуудал: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Б.Мөнхбат танилцууллаа.Үүнд:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевизээр 2 удаа зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2025 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хувьцааны тоо, хэмжээнд өөрчлөлт гараагүй, 2025 оны 03-р сарын 21-ний байдлаар компанийн 135266 ширхэг хувьцааг 101 хүн эзэмшдэг байсан, одоо 102 хүн эзэмшиж байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин хөлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудалд анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

2024 онд компанийн нэгж хувьцаанд 3550 төгрөг, нийт 480,194,300.0 төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2025 онд компанийн нэгж хувьцаанд 3800 төгрөг, нийт 514,010,800.0 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2024 оны ажлын үр дүнд "хангалттай" гэсэн дүгнэлт өгснийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу удирдлагын урамшилд 28.1 сая төгрөг олгожээ.

Бид өнгөрсөн онд 6 тэрбум 546,25 сая төгрөгийн БУА гүйцэтгэж, 1 тэрбум 700.0 сая төгрөгийн орон сууцны үйлчилгээний ажил, нийт 6 тэрбум 546.25 сая төгрөгийн барилга угсралт, ажил үйлчилгээ эрхэлж 5 тэрбум 894.9 сая төгрөгийн зардал гаргаж, барилга угсралтын хувьд 651.3 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт 806.2 сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд 404.4 сая төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

Манай Хүрд Финанс ББСБ 2025 оны 02-р сараас үйл ажиллагаа явуулж эхэллээ.

Хүрд Нарлаг ХХК-н барилгыг цэцэрлэгийн зориулалтаар түрээсэлж байгаа. Хүрд Нарлаг ХХК 2024 онд 200 сая, 2025 онд 240 сая, өнөөдрийн байдлаар 2026 онд компанид 100 сая төгрөг татан төвлөрүүлээд байна.

Ажлын үр дүн, компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

2-р асуудал: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлт тайланг гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин танилцууллаа.Үүнд:

2025 онд Хүрд ХК 79 орчим хүний бүрэлдэхүүнтэй Хүрд Нарлаг, Хүрд Финанс охин компани болон Үйлдвэрлэлийн алба, Захирлын ажлын алба, Хангамжийн алба, Санхүүгийн алба, Авто бааз, Орон сууц контор болон төмөр хийц, бетон хийцийн цехийн бүрэлдхүүнтэй ажиллалаа.

Компани 2025 онд доорх барилга угсралтын ажлыг гүйцэтгэлээ.

1. Увс аймгийн Улаангом сумын нутагт байрлах 10кВ-ын ЦДАШ, 0,4кВ-ын ЦДАШ, 10/0,4кВ-ын дэд өртөөнүүдийн шинэчлэлтийн ажлын 9,35 тэрбум төгрөгийн ажлын гэрээг 2025 оны 08-р сарын 31-нд байгуулсан. Улаангом сумын төвд байгаа 125 АТП дэд өртөөг КТПн болгон шинэчлэх, Эмнэлэг, Дов фидерийн 6кВ/0,4-ын агаарын шугамыг 10/0,4кВ болгож шинэчлэх ажлыг гүйцэтгэж, 2025 онд 2,53 тэрбум төгрөг санхүүжсэн.
2. Хайлааст: Согоотын 26-40-р гудамжны айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох ажил 5,6 тэрбумын өртөгтэй. 2024 оны 10-р сард барилга угсралтын ажил

5,6 тэрбумын өртөгтэй. 2024 оны 10-р сард барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажил эхлэх зөвшөөрөл 2025 оны 04-р сард гарсан. 2025 онд 2 тэрбум 140 сая төгрөг санхүүжсэн.

3. Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын шинэ суурьшлын бүсийн гадна инженерийн шугам сүлжээний ажил

Барилга угсралтын ажлын гэрээг 2024 онд байгуулсан боловч хөрөнгөгүйгээс 2 жил царцаж байгаа.

Компани 2026 онд дээрх 3 барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.

1. Увс аймгийн Улаангом сумын нутагт байрлах 10кВ-ын ЦДАШ, 0,4кВ-ын ЦДАШ, 10/0,4кВ-ын дэд өртөөнүүдийн шинэчлэлтийн ажлын хүрээнд 126 ширхэг агаарын дэд өртөөг иж бүрэн дэд өртөө КТПн болгох ажлаас 76ш КТПн, 6/0,4кВ хүчдэлийн түвшинг 10/0,4кВ болгож, Эмнэлэг, Дов фидерийн шугам сүлжээг шинэчлэх 6 тэрбум 820 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгдэнэ.

2. Хайлааст: Согоотын 26-40-р гудамжны айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох ажил Улсын төсөвт 2024 онд 2,4 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр тусгагдсан байсан нь ажил эхлээгүйгээс эргэж татагдсан. 2026 онд 845.7 сая төгрөг төсөвт тусгагдсан. Энэ дүнд шугам угсралтын ажлаа гүйцэтгэнэ.

3. Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын шинэ суурьшлын бүсийн гадна инженерийн шугам сүлжээний ажил

Барилга угсралтын ажлын гэрээг 2024 онд байгуулсан боловч хөрөнгөгүйгээс 2 жил царцаж байгаа. Одоо 1,25 тэрбум төгрөгийн ажил үлдсэн.

Эдгээр 3 ажил нийлээд 2026 онд 8.8 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэнэ

Бид өнгөрсөн онд **6 тэрбум 546,25 сая** төгрөгийн БУА гүйцэтгэж, **1 тэрбум 700.0 сая** төгрөгийн орон сууцны үйлчилгээний ажил, нийт **6 тэрбум 546.25 сая** төгрөгийн барилга угсралт, ажил үйлчилгээ эрхэлж **5 тэрбум 894.9 сая** төгрөгийн зардал гаргаж, барилга угсралтын хувьд **651.3 сая** төгрөгийн ашигтай, **1 төгрөгийн БУА-ыг 90 мөнгөөр** гүйцэтгэж, барилга угсралтын хувьд 10%-ийн ашигтай ажиллажээ.

Компанийн нийт борлуулалт 2025 онд **6 тэрбум 546.25 сая** төгрөг бөгөөд татварын өмнөх ашиг **4 тэрбум 630.2 сая** төгрөг, цэвэр ашиг **4 тэрбум 152.79 сая** төгрөг байна.

2025 оны компанийн мөнгөн орлогыг задалж харвал:

- БУА-ын ашиг : 651.3 сая төгрөг байна.
- Санхүүгийн үйлчилгээний ашиг Банкны хадгаламж, хувьцааны ашиг: 4 тэрбум 296.7 сая
- Түрээсийн ашиг: 187.0 сая төгрөг
- Бусад ашиг: 156.2 сая төгрөг байна.

Манай Хүрд Финанс ББСБ 2025 оны 02-р сараас үйл ажиллагаа явуулж эхэллээ. Өнөөдрийн байдлаар 5.0 тэрбум төгрөгийн зээл олгосноос 1,5 тэрбум төгрөг эргэн

төлөгдөж, 94 зээлдэгчтэй харилцаж байна. Зээлийн дундаж хүү 2,9%. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл одоогоор байхгүй.

Татварын өмнөх ашиг 383.0 сая төгрөг, татварын дараах ашиг 345 сая төгрөг.

Хүрд финанс ББСБ-ын анхны хөрөнгө оруулалт 2,5 тэрбум байсан. 2025 оны 10-р сард 500 сая төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02-р сарын 25-ны өдрийн “Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарь батлах тухай” 70 тоот тогтоолоор Улаанбаатар хотод 2026 оны 04-р сарын 10 гэхэд 3,5 тэрбум, 2028 оны 04-р сарын 10 гэхэд 5.0 тэрбум төгрөг байхаар заасан.

3-р асуудал: Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах.

Э.Тэмүүжин: Энэ онд компанийн бүтцэд өөрчлөлт оруулсныг удирдлагын зардалд тусгасан байгааг та бүхэн харж байгаа.

Компани тайланд дурдсанчлан 8,8 тэрбум төгрөгийн БУА гүйцэтгэнэ. Nova Residence төслийг хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөтэй байгаа.

Компанийн удирдлага 9 хүнтэй, цалингийн зардал 357,6 сая, урсгал зардал 231.1 сая, нийт **583,597** сая төгрөгийн зардлыг танилцуулж байна. Компанийн бүтэц: Гүйцэтгэх захирлын удирдлаганд Зөвлөх, Инженер техникийн алба, Санхүүгийн алба, Захиалагчийн алба, Удирдлагын алба, Орон сууцны контор гэсэн 6 хэлтэстэй ажиллана. Удирдлагын бүтцийн өөрчлөлт, зардлын бүтэцтэй танилцаад саналаа өгөөрэй.

Б.Мөнхбат: Та бүхний өмнө 2026 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал байна. Энэ талаар асууж тодруулах зүйл байна уу? 2025 оны компанийн удирдлагын зардлыг **63,703.3** мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан гэдгийг тайланд тусгасан.

Б.Мөнхбат: Компанийн бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын талаар өөр санал, асуулт байхгүй бол дэмжиж байгаа нь гараа өргөнө үү?

4-р асуудал: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулахаар санал оруулж байна. Компанийн дүрэмд ТУЗ-ийн гишүүдийг бүрэн эрх 4 жил гэж заасан байгаа. Энэ нь одоогийн цаг үетэй уялдахгүй, ТУЗ-ийн гишүүдийн идэвх сул байхад нөлөөлж байна. Солих үндэслэл:

- ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо сул тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.
- Компанийн стратеги зорилт, төлөвлөгөөтэй уялдуулан гадаад орчны хамаарал хийгээд шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжлийн нөхцөлд шаардлагатай ур чадвар, мэдлэг бүхий гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тухай бүр элсүүлэх шаардлагатай.

Компанийн дүрэмд заасан 4 жилийн хугацааг өөрчлөн компанийн тухай хуулийн 77.2.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит

хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно гэсэн заалтыг мөрдөх саналтай байна.

Дүрмийн шинэчилсэн найруулга:

- **ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа ба томилгоо**

7.18. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь томилогдсон өдрөөс эхлэн дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл буюу 1 (нэг) жил байна. Хугацаа дуусгавар болсон гишүүнийг дахин сонгож болно.

7.24 Гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх, солих

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ТУЗ-ийн аль ч гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас үл хамааран ямар ч үед үүрэгт ажлаас нь чөлөөлөх эрхтэй.

2. ТУЗ-ийн гишүүнийг шуурхай солих үндэслэлүүд:

- ТУЗ-өөс баталсан компанийн жилийн стратегийн зорилт, Гүйцэтгэх удирдлагын хяналтын үзүүлэлтүүд (KPI) хангалтгүй биелсэн;
- ТУЗ-ийн хурлын ирцэд 2 удаа дараалан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй;
- Мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасан эсвэл сонирхлын зөрчлөө нуун дарагдуулсан;
- Компанийн тухай хуулийн 77.2-т заасан шаардлага болон энэхүү дүрмийн 8.3-т заасан шалгуурыг хангахгүй болсон.

Компанийн дүрэмд оруулахаар танилцуулж байгаа өөрчлөлтүүд нь компанийн тухай хуулийн заалтуудыг үндэслэсэн болно.

7.27.20. Төлөөлөн дуирдах зөвлөл нь энэ дүрмийн 4.3 заасны дагуу хувьцааг халааслах шийдвэр гаргана. Компанийн халаас хувьцааны тоо нийт гаргасан хувьцааны 5 хувиас хэтэрч болохгүй. Хэвэр 5 хувиас хэтэрсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэртээ худалдан авах хувьцааны тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг зааж өгнө.

- Компанийн дүрэмд 7.27.19-гээд дууссан байдаг юм. Компанийн тухай хуулийн 41-р зүйл. "Компанийн өрийн бичиг"-т заасныг үндэслэн Компанийн дүрмийн 7-р бүлэг "ТУЗ" -т дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах.

7.27.20. ТУЗ нь энэ дүрмийн 4.3-т заасны дагуу хувьцааг халааслах шийдвэр гаргана. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрмийн 4.3 заасны дагуу хувьцааг халааслах шийдвэр гаргана. Компанийн халаас хувьцааны тоо нийт гаргасан хувьцааны 5 хувиас хэтэрч болохгүй. Хэвэр 5 хувиас хэтэрсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэртээ худалдан авах хувьцааны тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг зааж өгнө.

7.27.21 Компанийн өрийн бичиг /бонд/ гаргах

Компанийн өрийн бичиг /бонд/ гаргах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ гаргана.

ТУЗ-ийн шийдвэрт өрийн бичгийн нийт тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөл, барьцаа болон бусад баталгаа, энгийн хувьцаанд хөрвөх эсэх зэргийг нарийвчлан тусгана.

Компанийн гаргах өрийн бичгийн нийт дүн нь компанийн өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байна. Хэрэв өөрийн хөрөнгөөс давсан дүн бүхий өрийн бичиг гаргах бол хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

7.27.22 Хувьцаа гаргах

Компанийн энгийн, халаасны болон давуу эрхийн хувьцаа гүйлгээнд шинээр гаргах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана гэсэн нэмэлтийг оруулахаар санал оруулж байна.

5-р асуудал: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Манай компанийн ТУЗ-ийн гишүүдийг 2022 онд сонгосон бөгөөд компанийн дүрэмд заасны дагуу 4 жил ажиллаад энэ хурлаар бүрэн эрх нь дуусгавар болж байгаа юм. Тиймээс Компанийн ТУЗ-ийн гишүүдэд дараах хүмүүсийг санал болгож байна. /ТУЗ-ийн гишүүдийн товч анкетыг танилцуулав/

6-р асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: ТУЗ-ийн зүгээс 2 асуудлыг хуралд оруулж байна.

Эхний асуудал: Компанийн эзэмшлийн талбайд орон сууц барих Nova Residence төслийг танилцуулья. Энэхүү төслийг 2026-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй. 15 давхар 3 блок орон сууц, оффисын барилга төлөвлөсөн.

Барилгажилтын талбай 27000м², орон сууцны талбай 15000м², дулаан зогсоол 2933м², гадна зогсоол 992м, амралтын талбай 500м² байхаар зураг төслөө боловсруулж байна.

Энэ газарт 2017 оны 9-р сарын 3-нд зоорьтой 15 давхар 5 блок орон сууц барихаар А даалгавар батлуулсан. Гэвч 2 талд орон сууц барьснаар барилга хоорондын зайн хэмжээ зөрчигдөж, одоо 3 блок орон сууц барих нөхцөл бүрдэж А даалгаврын хүрээнд эскиз зураг ахин батлуулсан.

Орон сууц барих газар чөлөөлөхөд, улсын бүртгэлийн 2202005473 дугаарт бүртгэгдсэн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо Д.Сүхбаатарын гудамжид байрлах 100,700,000 төгрөгийн үнэ бүхий худалдаа үйлчилгээний зориулалттай 1 давхар барилгыг буулгах шаардлага гарч байна. Энэхүү барилга нь 1954 онд цехийн зориулалтаар барьсан. Нэгэнт үйлдвэрлэлийн зориулалтаар баригдсан болохоор төвийн халаалтгүй, бие засах газаргүй, гар угаах газаргүй гэх мэт эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүйгээс одоогоор ашиглалтгүй байгаа болно. Хотын 2035 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд буулгаж, орон сууцжуулахаар тусгагдсан байгаа.

Энэ онд Nova Residence төслийн 4 давхар хүртэл карказ цутгах төлөвлөгөөтэй байгаа. Орон сууцны төслийн санхүүжилт нийт 65 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгөөр

40% санхүүжүүлнэ. Урьдчилсан борлуулалтаар 40%, хөрөнгө оруулалтаар 20% санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байгаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ асуудлыг хэлэлцүүлж, төслийг хэрэгжүүлэхийг дэмжиж өгөхийг хүсье.

Дараагийн асуудал: Манай Хүрд Финанс ББСБ 2025 оны 02-р сараас үйл ажиллагаа явуулж эхэллээ. Өнөөдрийн байдлаар 5.0 тэрбум төгрөгийн зээл олгосноос 1,5 тэрбум төгрөг эргэн төлөгдөж, 94 зээлдэгчтэй харилцаж байна. Зээлийн дундаж хүү 2,9%. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл одоогоор байхгүй.

Хүрд финанс ББСБ-ын анхны хөрөнгө оруулалт 2,5 тэрбум байсан. 2025 оны 10-р сард 500 сая төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02-р сарын 25-ны өдрийн “Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуваарь батлах тухай” 70 тоот тогтоолоор Улаанбаатар хотод 2026 оны 04-р сарын 10 гэхэд 3,5 тэрбум, 2028 оны 04-р сарын 10 гэхэд 5.0 тэрбум төгрөг байхаар заасан.

Иймд ТУЗ-ийн хуралд ББСБ-ын хөрөнгийг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх хүсэлт оруулж хэрэгжүүлсэн. Байнгын сайн харилцагч, найдвартай зээлдэгчтэй болж, тасралтгүй үйл ажиллагаа явуулахын тулд эх үүсвэрээ 500,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх хүсэлтийг оруулж байна.

- Хүрд Финанс ХХК-д дүрмийн санг 500 сая төгрөгөөр нэмэгдүүлэх хүсэлтэд санал өгөх нь Компанийн тухай хуулийн 89.1-д зааснаар “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь сонирхлын зөрчилтөйд тооцогдох тул ээж С.Эрдэнэчимэгийн хамт санал өгөхөөс татгалзаж байгаа хурлын протоколд тэмдэглүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Тиймээс бусад хувьцаа эзэмшигчид энэ асуудлыг хэлэлцээд саналаа өгөөрэй.

Б. Мөнхбат: Дээрх асуудлуудын талаар Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Компанийн үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Хүүгийн орлогын 4,2 тэрбум төгрөгт Хүрд Финанс ББСБ-ын ашиг орж тооцогдсон уу? Өнгөрсөн оны борлуулалтын орлого түрүү жилийнхээс буурсан байгааг тайлбарлана уу?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Хайлааст: Согоотын 26-40-р гудамжны айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох ажил 5,6 тэрбумын өртөгтэй. Ажил эхлэх зөвшөөрөл 2025 оны 04-р сард гарсан. 2025 онд тавигдсан улсын төсвийн 2 тэрбум төгрөг татагдсан. Энэ нь ХББОС Яамны хариуцлагагүй үйл ажиллагаанаас болсон. Энэ ажлыг гүйцэтгэж эхлээд санхүүжилтээ авсан бол борлуулалт өндөр гарах байлаа.

ББСБ-ын ашиг хүүгийн орлогын 4,2 тэрбум төгрөгт ороогүй. Энэ орлогыг 20 тэрбум төгрөгийг 4 банканд хугацаатай хадгалах замаар бий болгосон. Тэгэхдээ 25% хүүтэй юм шиг харагдаж байгаа биз. Банкны хугацаатай хадгаламжийн хүү

14-15%.Бид банкны бусад бүтээгдэхүүн ашиглах замаар энэ орлогыг олсон. Бонд аваагүй.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Аудитлагдсан тайланд эргэлтийн бус хөрөнгө 4 тэрбум 10.0 сая байснаа 2025 онд 3.9 тэрбум болж өөрчлөгдсөнийг тайлбарлана уу?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Хөрөнгийн элэгдлэл хорогдол тооцсоноос ийм дүн гарсан. Тэрнээс хөрөнгө хасагдсан юм байхгүй ээ

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Орон сууцны төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө танилцууллаа. Өнөөдрийн нөхцөлд тээвэр, материалын үнэ өсөх гээд эрсдэл үүсч байгааг тооцсон уу?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Эрсдэл л байгаа. Тэгэхдээ Орон сууц барих төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Мөнгө санхүү нь байгаа ч зах зээлийн нөхцөл байдал тогтворгүй байгааг ойлгож байна. Шатахууны үнэ нэмэгдэх эрсдэл үүслээ. Материалын үнэ өсөх үү, шатахуун тасалдалгүй энэ хэвээрээ байх уу гэх мэт асуудал байгаа ч энэ онд уг төслийг эхлүүлнэ. 2026 оны зорилтот төлөвлөгөөнд барилгын карказыг 4 давхар хүртэл цутгана гэж тусгасан.

Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа одоо байгаа дээрх 2 ажил дээр нэмж ажил авах, худалдаа нийлүүлэлтийн тендерт оролцоно гэж төлөвлөж, 10,8 тэрбум төгрөгийн борлуулалттай байхаар төлөвлөсөн.

Удирдлагын зардлыг боловсруулахдаа цалингийн хэмжээг нэмэгдүүлж тооцсон. Бусад унаа, томилолт, хүлээн авалтын зардлыг багасгасан. Хэмнэх боломжтой зардлуудыг танасан. ТУЗ-ийн даргын цалинг сард 3,0 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүдийн цалинг хурлын ирцээр буюу улиралд 1 удаа хуралдахаар тооцсон байгаа. Өөр асуулт, санал байна уу?

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Өөрийн хөрөнгөөр барьж эхэлнэ гэсэн. Бидний нөгөө хүүгийн орлого байхгүй болно гэсэн үг үү?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Хүрд компанид тодорхой хэмжээний хөрөнгийн чадавх байна. Мөн хотын төвд гээд бидэнд давуу тал байгаа. Тиймээс орон сууц барих ажлыг эхлүүлнэ. Тэгэхдээ түлш шатахууны үнэ нэмэгдээд, зах зээлийн нөхцөл хүндэрвэл зогсоох байх.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Өөр асуулт, санал байхгүй бол Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2026 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, Nova Resident төсөл хэрэгжүүлэх, Хүрд Финанс ББСБ-ын хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлуудад санал хураалт явуулья.

Тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр саналын хуудсыг хураан авч, саналын хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж баталсан 124,421 саналын тоо 100 %,

- Татгалзсан саналын тоо%
- Түдгэлзсэн саналын тоо%
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэж баталсан **124,421** саналын тоо **100 %**
- Татгалзсан саналын тоо%
- Түдгэлзсэн саналын тоо%
3. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө баталсан **124,421** саналын тоо **100 %**
- Татгалзсан саналын тоо%
- Түдгэлзсэн саналын тоо%
4. Компанийн 2026 оны удирдлагын зардлыг баталсан **124,421** саналын тоо **100 %**
- Татгалзсан саналын тоо%
- Түдгэлзсэн саналын тоо%
5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан **124,421** саналын тоо **100 %**
- Татгалзсан саналын тоо%
- Түдгэлзсэн саналын тоо%
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй **124,421** ширхэг хувьцаа эзэмшдэг **9** хувь нийлүүлэгчийн саналын тоо:

№	ТУЗ-ийн гишүүд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Энхжаргал Тэмүүжин	124,629		
2	Бүлтэхүү Мөнхбат	124,395		
3	Галбадрах Гантуяа	124,395		
4	Энхжаргал Ундрах	124,395		
5	Бүлтэнхүү Сумьяа	124,395		
6	Балдорж Бат-Эрдэнэ	124,395		
	Хараат бус гишүүн			
7	Хяргас Цэвэлмаа	124,395		
8	Эрдэнэсүх Мөнх-Оргил	124,395		
9	Эрдэнэбилэг Батзориг	124,395		

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал- Nova Residence орон сууцны төслийг 2026-2028 онд хэрэгжүүлэхийг хэлэлцэж дэмжсэн **124,421** саналын тоо **100 %**
- Татгалзсан саналын тоо%
- Түдгэлзсэн саналын тоо%

8. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал- Хүрд ХК-ийн хуримтлагдсан ашгаас охин компани Хүрд Финанс ББСБ-ын дүрмийн санг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг олгохыг дэмжсэн 14,069 саналын тоо 100 %

Татгалзсан саналын тоо ...-....%

Түдгэлзсэн ...-.... саналын тоо ...-....%

ХУРЛЫН ШИЙДВЭР:


Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх гүйцэтгэх захирлын дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг батлав
4. Компанийн удирдлагын зардлыг батлав.
5. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлав.
6. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгож батлав.
7. Nova Residence орон сууцны төслийг 2026-2028 онд хэрэгжүүлэхийг хэлэлцэж дэмжив.
8. Хүрд Финанс ББСБ-ын дүрмийн санг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг олгохыг дэмжив.

Хурлын дарга Б.Мөнхбат тоологын комиссын шийдвэрийг үндэслэн, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслүүдийг гишүүдэд уншиж танилцуулж батлуулав.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 16.20 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА  Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ГАНТУЯА